



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Мэргэн Манал ӨЭМТ-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/120/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Г.Нандинжаргал
Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargal.g@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11315558 Цахим хаяг: altantsetseg.ya@audit.gov.mn

Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн захирал О.Бурмаа
Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.15 № 767
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН МЭРГЭН МАНАЛ
ӨЭМТ-ИЙН ДАРГА Н.УЯНГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Мэргэн Манал ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Мэргэн Манал ӨЭМТ нь анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын болон 4 төрөлт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 591.4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, 19,406 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/406 тоот тушаалаар 311/2025 дугаартай батламжаар 2 жилийн хугацаатай "Магадлан итгэмжлэгдсэн" эрүүл мэндийн байгууллага болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Мэргэн Манал ӨЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 20 байхаар баталж, тайлант онд 16 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Мэргэн Манал ӨЭМТ-ийн 2025 оны гурвалсан гэрээний биелэлт 93.2 хувь, ЭМДЕГ-тай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах гэрээний биелэлт 90.1 хувийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,893,979.60	13,909,002.19
1.1.02	Дансны авлага	7,509,452.57	8,142,018.20
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага		9,888.00
1.1.06	Бараа материал	12,932,620.00	6,189,900.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	24,336,052.17	28,250,808.39
1.2.01	Үндсэн хөрөнгө	168,812,206.95	160,263,526.14
1.2.02	Биет бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	168,812,206.95	160,263,526.14
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	193,148,259.12	188,514,334.53
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		593,430.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	593,430.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	593,430.00
2.3.01	Өмч: - төрийн		
2.3.02	-хувийн	10,000.00	10,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	193,138,259.12	187,910,904.53
2.3.11	Эздийн өмчийн дүн	193,148,259.12	187,920,904.53
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	193,148,259.12	188,514,334.53

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Нийт орлогын дүн	628,433,710.36	602,999,354.79
1.1	Санхүүжилтийн орлого	628,433,710.36	591,439,059.30
1.2	Бусад орлого		5,542,860.26
1.3	Туслах үйл ажиллагааны орлого		6,017,435.23
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
4	Нийт ашиг (алдагдал)	628,433,710.36	602,999,354.79
05	Хүүний орлого		365,684.75
09	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	476,345,732.16	597,943,713.66
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	152,087,978.20	5,421,325.88
19	Орлогын татварын зардал		36,568.47
20	Татварын дараах ашиг (алдагдал)	152,087,978.20	5,384,757.41
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	152,087,978.20	5,384,757.41
24	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	152,087,978.20	5,384,757.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	510,922,794.40	596,823,928.90
1.1.1	Татаас, санхүүжилтийн орлого	510,922,794.40	590,806,493.67
1.1.2	Туслах үйл ажиллагааны орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого		6,017,435.23
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	510,922,794.40	596,823,928.90
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	443,232,623.02	576,557,591.06
1.2.1	Ажилчдад төлсөн	259,223,869.94	351,390,984.50
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	75,599,088.03	100,958,311.96
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	24,861,499.47	47,743,076.61
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,650,000.00	5,214,379.40
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	150,000.00	2,000,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	26,771,676.80	36,427,395.38
1.2.9	Бусад мөнгөн зарлага	54,976,488.78	32,823,443.21
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	443,232,623.02	576,557,591.06
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	67,690,171.38	20,266,337.84
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	531,531.91	365,684.75
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	531,531.91	365,684.75
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	66,414,865.00	10,617,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	66,414,865.00	10,617,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(65,883,333.09)	(10,251,315.25)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	1,806,838.29	10,015,022.59
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,087,141.31	3,893,979.60
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,893,979.60	13,909,002.19

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрв.нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000.00	-	-	-	-	41,050,280.92	41,060,280.92
3	Залруулсан үлдэгдэл	10,000.00	-	-	-	-	41,050,280.92	41,060,280.92
4	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	152,087,978.20	152,087,978.20
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000.00	-	-	-	-	193,138,259.12	193,148,259.12
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	(10,612,112.00)	(10,612,112.00)
11	Залруулсан үлдэгдэл	10,000.00	-	-	-	-	182,526,147.12	182,536,147.12
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	5,384,757.41	5,384,757.41
17	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,000.00	-	-	-	-	187,910,904.53	187,920,904.53

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 84,637.6 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс 84,637.6 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Орлого үр дүнгийн тайланд хүүгийн орлогын татварын зардлыг 36.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 47,807.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Татварын байгууллагад төлсөн 36,427.4 мянган төгрөгийн зардлыг буруу тайлагнасныг;
- Цахим орлогын татварын тайланд 365.7 мянган төгрөгийн хүүгийн орлогыг тусгай хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоололд тусган илэрхийлээгүй тайлагнасныг тус тус залруулав.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4;2020 стандартын 5.2.1.7.2-т иж бүрэн байх -санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дасны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх гэж заасныг болон санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 10,612.1 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 10,612.1 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 10,612.1 мянган төгрөгийн материаллаг бус залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой

Илрүүлэлт-1: Санхүүгийн аудитлагдсан тайлангийн эхний үлдэгдэл 10,612.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 үнэн зөв байх, 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтуудыг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн аудитлагдсан тайлангийн эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Мөнгөн гүйлгээний тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 47,807.9 мянган төгрөгийг дутуу тайлагнасан.	1	47,807.9			1	47,807.9	1	47,807.9				
2	Орлого үр дүнгийн тайланд хүүгийн орлогын татварын зардлыг 36.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	36.6			1	36.6	1	36.6				
3	Мөнгөн гүйлгээний тайлангийн татварын байгууллагад төлсөн 36,427.4 мянган төгрөгийн зардлын ангиалалын буруу тайлагнасан.	1	36,427.4			1	36,427.4	1	36,427.4				
4	Цахим орлогын татварын тайланд 365.7 мянган төгрөгийн хүүгийн орлогыг тусгай хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоололд тусган тайлагнаагүй байна.	1	365.7			1	365.7	1	365.7				
	Дүн	4	84,637.6			4	84,637.6	4	84,637.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн аудитлагдсан тайлангийн эхний үлдэгдэл 10,612.1 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	10,612.1					1	10,612.1
	Дүн	1	10,612.1					1	10,612.1